

Хувь нийлүүлэгчдийн 2016 оны ээлжит

хурлын тэмдэглэл

Хурлыг 2017 оны 4 дүгээр сарын 30 ний өдрийн 09 цаг 30 минутанд өөрийн байранд эхлэв.

Оролцсон нь:

- | | |
|-------------------|--|
| 1. Н.Соёмбо | ТУЗ-ийн дарга - / 35544 ширхэг хувьцаа эзэмшигч/ |
| 2. М.Алтанцэцэг | ТУЗ-ийн гишүүн Гүйцэтгэх захирал |
| 3. Н.Тулга | ТУЗ-ийн гишүүн |
| 4. Э.Норовринчин | ТУЗ-ийн гишүүн |
| 5. Б.Нямдэлгэр | Урилгаар оролцогч |
| 6. Ж.Жаргалсайхан | Урилгаар оролцогч |
| 7. Н.Хишигсүрэн | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 8. Т.Батжаргал | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 9. Б.Бадрал | Урилгаар оролцогч |
| 10. Б.Баярцэнгэл | Компанийн менежер, санхүүч |
| 11. Д.Уртнасан | Компанийн ажилтан |
| 12. Г.Даваажаргал | Компанийн гэрээт ажилтан |

Хурлын ирц 67,63 хувь байгааг компанийн менежер Б.Баярцэнгэл танилцуулж Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг эхлүүлэв.

Хурлын даргад компанийн ТУЗ-ийн дарга Н.Соёмбо өөрийн нэрээ, Хурлын нарийн бичгийн даргад компанийн гүйцэтгэх захирал М.Алтанцэцэгийн нэрийг дэвшүүлж оролцогсдын 100% ийн саналаар дэмжиж хурлын дарга, нарийн бичгийн дарга нарыг сонголоо.

Хуралдагсдад хурлын дэгийг хурлын дарга Н.Соёмбо танилцуулж 100 хувийн саналаар баталлаа.

Хэлэлцсэн нь:

1. 2016 оны санхүүгийн тайлан баланс
2. Аудитын дүгнэлт
3. 2016 оны үйл ажиллагааны тайлан
4. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар улсын чанартай зохион байгуулагдах ажилд биечлэн оролцох үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал хэлэлцэх шийдвэр гаргах
5. Компанийн 2017-2021 онуудад хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөг баталж, санал солилцож шийдвэр гаргах
6. Компанийн ТУЗ-ийн зарим гишүүнийг чөлөөлөх, шинээр сонгох
7. Хууль болон компанийн дүрмийн дагуу бусад асуудал

Хурлын явц:

1.Компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансын байдлыг компанийн менежер, санхүүч Б.Баярцэнгэл танилцууллаа. Тэрээр компанийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийн байдал, бусад аж ахуйн нэгж байгууллагын авлага, өглөг бүх төрлийн татварийн төлөлт, зээл төлөлт, ашиг, алдагдал ямархуу түвшинд байгаа талаар 2015 он болон 2016 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг харьцуулсан судалгаан дээр үндэслэн тодорхой ярьж танилцууллаа. Компани цаашдаа үйл ажиллагааныхаа чиглэлээр дорвитой ажил гүйцэтгэх, эдийн засгийн хямралыг сөрөн туулах, хүний нөөцийн чадамжаа ашиглан шат дараатай тодорхой үйл ажиллагааг зохион байгуулж орлогоо нэмэгдүүлэх, компанийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах шаардлагатай байна гэдгийг уламжлав.

2.Тус компани 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансдаа “Б ЭНД С АУДИТ” ХХК-р баталгаажуулалт хийлгэж “Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу, бусад хууль тогтоомж дүрэм журмыг үндэслэн үнэн зөв хийж гүйцэтгэсэн байна гэсэн дүгнэлтийг өгчээ гэв.

3.“Мон-Гео” ХК нь тайлант хугацаанд компанийн тухай хууль компанийн дүрэм батлагдсан дотоод журмууд СЗХ-оос батлан гаргасан журам ХНХурлын болон компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэрүүдийг биелүүлэх чиглэл баримтлан үйл ажиллагаагаа явуулсан болно. Мөн “ҮЦТХТөв” ХХК, СЗХороо, МХБиржтэй хамтран ажиллажээ. Өнгөрсөн хурлаар шийдвэрлэсэн асуудлуудыг эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан биелүүлж ажиллаж чадсангүй. Байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор төмс, хүнсний ногоо тариалах төслийн эхний шатыг эхлүүллээ. Мөн хөрөнгө оруулалтын ажилд ч төдийлөн амжилт гаргаагүй болно. Цаашдын зорилтын талаар 5 асуудлыг санал хэлэлцүүлэхээр танилцуулж байна гэж гүйцэтгэх захирал М.Алтанцэцэг ярилаа.

4.ТУЗ-ийн дарга Н.Соёмбо Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой өмнө онуудад чанарын сайн үнэлгээтэйгээр хийж гүйцэтгэсэн төслийн ажлуудын талаар дэлгэрэнгүй ярьж танилцуулав.

1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил барилгын зураг төсөл кадастрын зураглал хийх үндсэн чиглэлийн ажлуудаа эрхлэх боломжит нөхцөл байдлыг судлах, хэрэгжүүлэх хэрэгтэй гэв.

5.Улс орон болон ААН байгууллага хувь хүмүүсийн эдийн засгийн чадавхи хэдий хугацаанд арилахыг үл харгалзан 2017-2021 онуудад хэрэгжүүлэх шинэчлэн боловсруулсан “Бизнес төлөвлөгөө” төслийн талаар энэхүү хурлаар хэлэлцүүлэхээр оруулж байна.

6.Компанийн 2017-2021 онуудад хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөг менежер Б.Баярцэнгэл танилцуулав. Энэхүү бизнес төлөвлөгөөг шат дараалан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж чадвал орон сууц, бүтээн байгуулалтын салбарт хөрөнгө оруулж буй компаниудын үйл ажиллагааг дэмжих, хүн амын орон сууцны эрэлт хэрэгцээг хангахад тодорхой хэмжээгээр нөлөөлөх, цаашид компанийн хөрөнгө орлогын хэмжээ нэмэгдэх, үйл ажиллагаа өргөжих гэх зэрэг олон боломжууд гарч ирэх юмаа.

7.Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байсан Х.Анар Австри улсад ажиллахаар явсан тул ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх,

1.Н.Соёмбо

2.М.Алтанцэцэг

3.Э.Норовринчин

4.Н.Тулга

5.Ж.Жаргалсайхан

6.Т.Батжаргал

7.Н.Хишигсүрэн

8.Б.Нямдэлгэр

9.Б.Бадрал нарын нэрийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохоор Б.Баярцэнгэл танилцуулав. Б.Баярцэнгэл ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулгыг хэлж, хэлэлцүүлэхээр санал оруулж байна гэв.

Санал шүүмжлэл

Хурлын дарга хүн бүр асуух, ярих зүйлээ 3-5 минутанд багтаана гэдгийг сануулав.

Н.Тулга: Компанийн 2016 оны Санхүү татварын болон үйл ажиллагааны тайланг сонслоо Түрээслэгч нар нь багассан үйл ажиллагаа нь тийм ч сайн биш явагдаж байгаа юм байна. Хөрөнгө мөнгөний хомсдолыг яаж арилгахав? Ямар нэгэн санаа оноо байгаа юу?

Б.Баярцэнгэл: Тийм, ээ одоохондоо бид зөвхөн түрээсийн орлого л харж ажиллаж байгаа. Эдийн засгийн хямрал арилбал бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлж орлого нэмэгдүүлж болох юм.

М.Алтанцэцэг: Гадна дотны байгууллагыг судалж хамтран ажиллах боломжуудыг эрэлхийж ер нь л дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Н.Тулга: Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг зөвшөөрч байна. Мөн ТУЗ-д нэр дэвшигчдийг дэмжиж байна.

Н.Соёмбо: Тайлангуудын байдлыг сонсож мэдлээ Санхүүгийн хувьд цалин, зарим татвар, цахилгаан, дулаан, усны төлбөрүүдээ төлөөд байдаг бие даасан санхүүгийн

чадвар байгаа юм байна. Энэ нь сайн хэрэг боловч зээл бас авдаг юм байна. Тэгээд цаашид энэ байдлаараа л явах уу?

Б.Баярцэнгэл: Ийм байдалтай байгаа нь үнэн Хөрөнгө оруулалтын асуудлыг дорвитой шийдэж үйл ажиллагааны чиглэлээ баримтлан ажиллах шаардлага зүй ёсоор гарч байгаа юмаа. Тийм тохиолдолд энэ байдал арилна гэж тооцож байна.

Н.Соёмбо: ТУЗ-д нэр дэвшигчдийг дэмжиж байна.

Э.Норовринчин: Компанийн 2016 оны Санхүүгийн тайлан баланс үйл ажиллагааны тайланг сонслоо? зөвхөн байрныхаа түрээсийн орлогоор л компани явж байгаа юм байна. Ер нь ТУЗ-ийн гишүүд компанийн бусад холбогдох хүмүүс дор бүрнээ хамтран ажиллах, компанийн эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга замуудыг олох шаардлагатай байнаа гэсэн байдал ажиглагдлаа. Тодорхой шийдэл олох хэрэгтэй гэж үзэж байна ТУЗ-д нэр дэвшсэн хүмүүсийг дэмжиж байна гэв.

Т.Батжаргал: Цаг зуурын бэрхшээл хямралыг даваад гарчихвал бидэнд ирээдүй байна.Ажлаа зөв зохион байгуулан ажиллах л хэрэгтэй. Нэг асуулт тавъя? Улсын төсвөөр сайхан ажлуудыг сайн гүйцэтгэсэн юм байна. Ямар нэгэн тендерт оролцоод амжилт гаргачихвал геологийн мэргэжлийн хүмүүс бэлэн байгаа юу?

М.Алтанцэцэг: Манай компанийн 2006-2009 онуудад геологийн хайгуул, зураглал зэрэг ажлуудыг биечлэн хийсэн геологийн инженер, техникч бүх хүмүүс маань бэлэн байгаа. Өнгөрсөн 2015 оны ашигт малтмалын хайгуулын ажлын тусгай зөвшөөрөл авах сонгон шалгаруулалтанд бүгд оролцсон. Мөн тэд мэргэжлийн ажлаа түр хугацаагаар өөр компанид гүйцэтгээд явж байгаа.

Н.Тулга: 1:50000-ны масштабын зураглал, хайгуул, ерөнхий эрлийн ажлын тухай тендер зарлагдахад хамтраад оролцъё. Компани судалгаа, эрэлхийлэл сайн хийх хэрэгтэй.

Н.Хишигсүрэн: Хурлаар хэлэлцэгдэж байгаа зүйлсийг сонслоо. Компанийн үйл ажиллагаа цар хүрээтэй чиглэлээ барьсан байдлаар явагдахгүй байгаа юм байна.Гэвч энэ нь цаг хугацааны л асуудал байх гэж бодож байна. Цаашдаа их зүйл хийх хэрэгтэй Үүний тулд хамтран ажиллаж гарц олъё, хямралыг давъя гэж хэлье дээ ТУЗ-д нэр дэвшигчдийг дэмжиж байна.

Санал шүүмжлэлийг таслав

Шийдвэрлэсэн нь:

- 1.Компанийн 2016 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг зөвшөөрөхөөр,
2. Аудиторын дүгнэлтийг зөвшөөрөхөөр,

3. Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар улсын чанартай зохион байгуулагдах ажилд биечлэн оролцохоор,

4.Эдийн засгийн хямралтай байдлаас гарах зорилгоор компанийн 2017-2021 онуудад хэрэгжүүлэх шинэчлэн боловсруулсан “Бизнес төлөвлөгөө” төслийг боломжтой нөхцөл бүрдмэгц хэрэгжүүлж эхлүүлэхээр,

5.Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор их хэмжээний хэлцэл хийх, зээл авах, тендерт оролцохыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөхөөр,

6. Хөрөнгө оруулалт, ердийн болон давуу эрхтэй хувьцааны талаар судлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тухайн цаг үед нь шийдвэртэй арга хэмжээ авч байхыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгохоор,

7.Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Х.Анарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөхөөр,

8.Компанийн ТУЗ-ийн гишүүнээр:

1. Н.Соёмбо
2. М.Алтанцэцэг
3. Н.Тулга
4. Э.Норовринчин
5. Б.Нямдэлгэр
6. Ж.Жаргалсайхан
7. Н.Хишигсүрэн
8. Т.Батжаргал
9. Б.Бадрал нарыг тооллогын комиссын шийдвэрээр сонгохоор тус, тус шийдвэрлэв.

Хурлыг 2017 оны 04дүгээр сарын 30-ны өдрийн 14 цаг 42 минутанд дуусгав.

Тэмдэглэл хөтөлсөн:



Г.Даваажаргал

Танилцсан:

1.Н.Соёмбо

ТУЗ-ийн дарга

2.М.Алтанцэцэг ТУЗ-ийн гишүүн

3.Н.Тулга ТУЗ-ийн гишүүн *Н.Тулга*

4.Э.Норовринчин ТУЗ-ийн гишүүн *Э.Норовринчин*

5.Б.Нямдэлгэр ТУЗ-ийн гишүүн *Б.Нямдэлгэр*

6.Ж.Жаргалсайхан ТУЗ-ийн гишүүн *Ж.Жаргалсайхан*

7.Н.Хишигсүрэн ТУЗ-ийн гишүүн *Н.Хишигсүрэн*

8.Т.Батжаргал ТУЗ-ийн гишүүн *Т.Батжаргал*

9.Б.Бадрал ТУЗ-ийн гишүүн *Б.Бадрал*

10.Б.Баярцэнгэл Компанийн менежер *Б.Баярцэнгэл*

11.Д.Уртнасан Компанийн ажилтан *Д.Уртнасан*

12.Г.Даваажаргал Компанийн гэрээт ажилтан *Г.Даваажаргал*

Баталгаажуулсан:

Хурлын дарга *Н.Соёмбо*

Хурлын нарийн бичгийн дарга *М.Алтанцэцэг*

